



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/110

Мандалговь

Сургуулийн өмнөх боловсролын
байгууллагын эрхлэгчид мэргэжлийн
зэрэг олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "а", Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.16, Монгол Улсын боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/117 дугаар тушаалаар батлагдсан "Хүүхдийн цэцэрлэгийн багш, арга зүйч, эрхлэгчид мэргэжлийн зэрэг олгох, хасах журам"-ын 3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын 5 дугаар сарын 20-ны өдрийн арга зүйн зөвлөлийн саналыг үндэслэн 2018-2019 оны хичээлийн жилд "Заах аргач" мэргэжлийн зэрэг шинээр олгох эрхлэгч нарын нэрсийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Мэргэжлийн зэргийн нэмэгдлийг 2020 оны төсвийн саналд тусгаж, тухайн оны нэгдүгээр сарын 1-ний өдрөөс тооцон олгохыг сургалтын байгууллагын эрхлэгч, нягтлан бодогч нарт үүрэг болгосугай.

Гурав. Журмын хэрэгжилтэнд хяналт тавьж, арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (А.Нарантуяа), Боловсрол, соёл, урлагийн газар (Ц.Бумангэрэл)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190675

Аймгийн Засаг даргын 2019 оны
..... дугаар сарын -ны өдрийн
..... дугаар захирамжийн хавсралт

“ЗААХ АРГАЧ” МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ШИНЭЭР ОЛГОХ
ЭРХЛЭГЧДИЙН НЭР

№	Нэр	Байгууллага, албан тушаал
1	М.Туул	Сайнцагаан сумын 2 дугаар цэцэрлэгийн эрхлэгч
2	Г.Мөнхтуяа	Сайнцагаан сумын Улсын тэргүүний 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч
3	С.Алимаа	Сайнцагаан сумын Улсын тэргүүний 4 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч
4	Л.Дэлгэрмаа	Сайнцагаан сумын 5 дугаар цэцэрлэгийн эрхлэгч
5	Л.Дэлгэрмаа	Сайнцагаан сумын 7 дугаар цэцэрлэгийн эрхлэгч
6	Д.Будням	Дэлгэрхангай сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч
7	Х.Цэрэн	Эрдэнэдалай сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч
8	Ц.Туяацэцэг	Хулд сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч
9	Х.Эрдэнэтуяа	Дэлгэрцогт сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч